

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.10.20

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- III улирлын ашиг орлогын улирал албан ёсоор эхэлж, мягмар гарагт хэд хэдэн томоохон банк тайлангаа нийтэлжээ. JPMorgan Chase, Citigroup, болон Wells Fargo бүгд таамгаас давсан үр дүн зарласан байна.
- S&P 500-ийн бүрэлдэхүүнд багтдаг компаниудын 12 орчим хувь нь ашиг орлогоо тайлагнасан бөгөөд тэдгээрийн 86 хувь нь шинжээчдийн таамгийг давж гарсан.
- Хувьцааны зах зээлийн ирэх 30 хоногийн хэлбэлзлийг хэмждэг CBOE Volatility Index (VIX) пүрэв гарагт дөрөвдүгээр сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрчээ.
- Уг өндөр түвшний улс төрийн уулзалт аравдугаар сарын 20-23-нд болох бөгөөд энэ үеэр дээд удирдлагууд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн дараагийн тавант жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, батлахаар төлөвлөж байна.

S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.10.13-10.19

АНУ-ЫН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД СЭРГЭЖ БАЙНА.

АНУ-ын хувьцааны зах зээл өнгөрсөн долоо хоногт өсөлттэй байлаа. Өмнөх баасан гарагийн огцом уналтаас болж S&P 500 индекс дөрөвдүгээр сараас хойших хамгийн муу гүйцэтгэлийг үзүүлсэн ч сэргэж чаджээ. Хувьцааны зах зээл тогтворгүй, савалгаатай долоо хоног өнгөрсөн бөгөөд АНУ болон Хятадын төлөөлөгчид худалдааны маргааны хурцадмал байдлыг зөөлрүүлсэн мэдэгдэл хийсний дараа эерэг уур амьсгал бүрдсэн юм.

Холбооны Нөөцийн банкны (ХНС) зарим албан тушаалтны зөөлөн өнгө аястай мэдэгдэл болон хиймэл оюун ухааны (AI) салбар дахь хэд хэдэн хэлэлцээр хөрөнгийн индексүүдийг өсөлтийг дэмжсэн байна. Мөн III улирлын ашиг орлогын улирал албан ёсоор эхэлж, мягмар гарагт хэд хэдэн томоохон банк тайлангаа нийтэлжээ. JPMorgan Chase, Citigroup, болон Wells Fargo бүгд таамгаас давсан үр дүн зарласан байна.

Баасан гарагийн өглөөний байдлаар S&P 500-ийн бүрэлдэхүүнд багтдаг компаниудын 12 орчим хувь нь ашиг орлогоо тайлагнасан бөгөөд тэдгээрийн 86 хувь нь шинжээчдийн таамгийг давж гарсан гэж FactSet-ийн мэдээлэлд дурджээ. Энэ нь долоо хоногийн турш хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйг дэмжсэн гол хүчин зүйл болсон байна.

Зээлжих зэрэглэл доогуур автомашины зээл олгодог санхүүгийн компани болон нэгэн авто сэлбэгийн компани дампуурлаа зарласантай холбогдон, зээлийн зах зээлийн эрсдэл нэмэгдсэн байна. Үүний улмаас хувьцааны зах зээлийн ирэх 30 хоногийн хэлбэлзлийг хэмждэг CBOE Volatility Index (VIX) пүрэв гарагт дөрөвдүгээр сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрчээ.

Холбооны Нөөцийн банкны (ХНС) дарга Жером Пауэлл төв банк энэ онд дахин богино хугацаат хүүгээ бууруулах хэвээр байгааг илтгэсэн байр суурь илэрхийллээ. Пауэлл мягмар гарагт болсон нэгэн арга хэмжээнд үг хэлэхдээ ХНС-ийн есдүгээр сарын дунд үеийн хуралдааны дараа хэлсэн үгсээ давтан дурдсан бөгөөд “ажил эрхлэлтийн буурах эрсдэл” нэмэгдэж байгаа нь эдийн засгийн эрсдэлийн тэнцвэрийг өөрчилж байна гэж онцолсон байна.

Үүнтэй холбогдон хөрөнгө оруулагчид инфляци зорилтот түвшнээс өндөр хэвээр байгаа ч төв банк ирэх хурлаараа зээлийн хүүг бууруулах чиглэлээ үргэлжлүүлэх магадлал өндөр гэж үзэж байна. Мөн ХНС-ийн бусад албан тушаалтнууд болох Кристофер Уоллер болон Стивен Миран нар энэ онд дахин хүү бууруулахыг дэмжсэн агуулгатай мэдэгдэл хийжээ.

Лхагва гарагт ХНС жилд найман удаа нийтэлдэг “Beige Book” тайлангаа гаргасан бөгөөд тус тайланд ХНС-ийн 12 бүс нутгийн банк тус бүрийн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, өгөгдлийг нэгтгэдэг. Тус тайланд өмнөх тайлангаас хойш эдийн засгийн идэвх “ихээхэн өөрчлөгдөөгүй” гэж тэмдэглэжээ. Бүс нутгуудад харилцан адилгүй дүр зураг ажиглагдсан бөгөөд хөдөлмөр эрхлэлт тогтвортой, цалин өссөн ч хэрэглэгчийн зардал “бага зэрэг буурсан”, “үнэ цаашид өссөн”, харин “ажил олгогчдын тоо буурсан” гэж дүгнэсэн байна.

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.10.13 – 10.19

БНХАУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ

БНХАУ-ын эх газрын хөрөнгийн зах зээл АНУ-тай худалдааны хурцадмал байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор уналттай байлаа. FactSet-ийн мэдээлснээр дотоодын гол үзүүлэлт болох CSI 300 индекс 2.22%-иар, Шанхайн нэгдсэн индекс 1.47%-иар буурсан байна. Харин Хонг Конг дахь Hang Seng индекс 3.97%-иар унажээ.

Эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд, БНХАУ есдүгээр сард үйлдвэрийн үнийн индекс (factory gate prices) өмнөх оноос 2.3%-иар буурсан гэж мэдээллээ. Энэ нь дараалан 36 дахь сардаа уналттай байгаа үзүүлэлт бөгөөд буурах хурд нь наймдугаар сарын 2.9%-ийн уналтаас бага зэрэг саарсан байна. Харин хэрэглээний үнийн индекс (CPI) 0.3%-иар буурсан нь эдийн засагчдын дундаж таамгаас илүү огцом бууралт байв. Гэхдээ хүнс болон эрчим хүчийг хассан суурь инфляцийн индекс 1.0%-д хүрч, сүүлийн 19 сарын дээд түвшинд хүрсэн нь тодорхой эерэг дохио байлаа. Гэсэн ч нийт инфляцийн мэдээллээс үзэхэд, цар тахлын дараах үнийн уналт болон үл хөдлөх хөрөнгийн урт хугацааны уналтаас шалтгаалан БНХАУ-ын эдийн засаг дефляцийн дарамтад хэвээр байгаа нь илт байна.

Бодлогын тал дээр, шинжээчид Хятадын Коммунист намын IV хурлыг анхааралтай ажиглаж байна. Уг өндөр түвшний улс төрийн уулзалт аравдугаар сарын 20-23-нд болох бөгөөд энэ үеэр дээд удирдлагууд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн дараагийн тавант жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, батлахаар төлөвлөж байна. Шинжээчид хурлын үеэр дотоодын хэрэглээг дэмжих бодлого, мэдэгдэл гарах эсэхэд онцгой анхаарал хандуулж байгаа бөгөөд энэ нь АНУ-ын өндөр тарифын дарамтын үед эдийн засгийн тэнцвэрийг сэргээх Хятадын гол зорилт гэж үзэж байна.

Golomt_Capital created with TradingView.com, Oct 20, 2025 11:54 UTC+8

Hang Seng Index Futures - 1D - HKEY 025,228 H25,978 L25,197 C25,868 +643 (+2.55%) +643 (+2.55%)



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning October 13, 2025									
		Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
		Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning October 20, 2025									
		Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
		Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers